

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.09.23 - 09.27

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа. Мөн зах зээлийн үнэлгээ өндөр компаниудын хувьцааны ханш зах зээлийн үнэлгээ бага компаниудтай харьцуулахад илүү өсөлт үзүүлсэн дахин нэг долоо хоног болов.

S&P 500 индексийн сагсанд багтах ус, дулаан, цахилгаан хангамжийн салбарын компаниудын хувьцаа өсөлттэй байсан бол харилцаа холбоо, эрүүл мэнд болон эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа уналттай байлаа.

Баасан гарагт, Endeavor компани WeWork компанийн адилаар нээлттэй компани болох хугацаагаа зах зээлийн тааламжтай нөхцөл бүрдэх хүртэл хойшлуулах боллоо.

АНУ-ын эрх баригчид худалдааны хэлэлцээртэй холбоотой уулзалтыг 10-р сарын 7-ны өдөр зохион байгуулагдах болсныг мэдэгдсэнтэй холбоотой хөрөнгийн зах зээлийн индексүүд өссөн боловч АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп, Мягмар гарагт НҮБ-ын өмнө тавьсан илтгэлдээ БНХАУ-ыг оюуны өмч болон худалдааны нууцын хулгай хийдэг хэмээн шүүмжилсэнтэй холбоотой хөрөнгийн зах зээлийн индексүүд огцом унасан байна.

Мөн АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трампыг огцруулах саналыг Танхимын Дарга хатагтай Нэнси Пелоси дэмжсэн нь хөрөнгийн зах зээлийн индексүүд дахин буурахад хүргэжээ.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүдэд бүс нутгуудын эдийн засгийн удаашрал болон худалдааны маргааны асуудлууд сөргөөр нөлөөлж байгаа ба энэ долоо хоногт Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд бага зэрэг уналттай хаагдлаа.

Brexit-ын эцсийн хугацаа болох 10-р сарын 31-ний өдөр ойртохын хэрээр Парламент болон Ерөнхий сайд ноён Борис Жонсоны хоорондын тэмцэл хурцадмал байдалд оров. Их Британи улсын дээд шүүхээс ноён Жонсоны Парламентыг түдгэлзүүлэх шийдвэр хууль бус хэмээн дүгнэсэн ба Парламентаас ноён Жонсонг ажлаа хүлээлгэж өгөхийг шаардаж байгаа юм.

Шинжээчид, Их Британи улсыг ямар нэг хэлэлцээргүйгээр Европын холбооноос гарах магадлал 55%, эцсийн хугацаа сунгагдах магадлал 35% харин хуучин санал болгосон хэлэлцээрт өөрчлөлт оруулан Парламентаар батлуулах магадлал 10% байгаа гэж үзэж байна.

Япон: Дэлхийн эдийн засгийн удаашрал мөн АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргааны асуудлуудаас үүдэн Япон улсын үйлдвэрлэлийн салбар уналтад оржээ. Япон улсын үйлдвэрлэлийн салбарт сөргөөр нөлөөлж буй бусад хүчин зүйлсээс дурдвал, Хонг Конгийн эсэргүүцлийн жагсаал, Brexit-ын асуудал, Япон улс болон Өмнөд Солонгос улсын харилцааны хурцадмал байдал болон 10-р сараас Япон улсад хэрэгжиж эхлэх нэмэгдсэн татварын хууль зэрэг юм.

Япон улсын Төв банкнаас эдийн засгийг дэмжих арга хэмжээ авахаа илэрхийлж байсан ба шижээчдийн үзэж байгаагаар 10-р сарын Мөнгөний бодлогын уулзалтаар эдийн засгийг дэмжих арга хэмжээ авах магадлалтай юм.

БНХАУ: БНХАУ-ын эрх баригчид 8-р сард үйлдвэрлэлийн компаниудын гарц болон ашигт ажиллагаа буурсныг мэдээлсэн байна. Энэхүү бууралт нь Төв Банкнаас эдийн засгийг дэмжихээр бодлогын хүүг бууруулсны дараа гарсан үр дүн тул БНХАУ-ын эрх баригчдын хувьд санаа зовних асуудал болжээ.

БНХАУ-ын үндэсний баяр тохиож буй ба тус баяр 10-р сарын 1-ээс 7-ны өдөр хүртэл үргэлжлэх тул тус хугацаанд биржүүд ажиллахгүй болно.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,976.00	-0.06% ▼
Dow Jones	АНУ	26,820.25	-0.43% ▼
S&P 500	АНУ	2,961.79	-1.01% ▼
Nasdaq	АНУ	7,939.63	-2.19% ▼
S&P/TSX	Канад	16,694.27	-1.22% ▼
FTSE 100	Их Британи	7,426.21	1.11% ▲
S&P/ASX 200	Австрали	6,716.10	-0.22% ▼
Nikkei 225	Япон	21,878.90	-0.91% ▼
Hang Seng	Хонг Конг	25,954.81	-1.82% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.12
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.30
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.00
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.31
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.12
DBM' 2023	USD	7.250%	104.10
TDBM' 2020	USD	9.375%	102.88
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	99.03

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.032	-0.01 ▼
Libor 3M	2.099	-0.04 ▼
Libor 6M	2.063	-0.01 ▼
Libor 1YR	2.043	-0.02 ▼
US 2YR Bond	1.626	-0.06 ▼
US 3YR Bond	1.571	-0.05 ▼
US 5YR Bond	1.559	-0.04 ▼
US 10YR Bond	1.680	-0.04 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.09.27	Өөрчлөлт
USD	2,667.64	-0.01% ▼
CNY	374.51	-0.50% ▼
EUR	2,912.80	-1.20% ▼
RUB	41.42	-0.93% ▼
KRW	2.23	-0.45% ▼
JPY	24.74	0.08% ▼
CAD	2,010.43	-0.02% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,497.01	-1.31% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	17.54	-2.50% ▼
Зэс	USD/lb.	259.75	-0.35% ▼
Нүүрс	USD/MT	69.82	-0.50% ▼
WTI газрын тос	USD/bbl.	55.91	-3.75% ▼
Brent газрын тос	USD/bbl.	61.91	-3.69% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VIII	8.90%
Бодлогын хүү	2019. VIII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VIII	11.26%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VIII	11.42%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VIII	4.99%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VIII	16.94%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VIII	10.75%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 41 компанийн 1,357.4 сая төгрөгийн 8,989,415 ширхэг хувьцаа арилжаалагдав.


“Улсын их дэлгүүр” /UID/ компанийн хувьцаа 14.29%-аар буюу хамгийн ихээр өсөж 800.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Авто импекс” /AOI/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 1,275.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 3,016 ширхэг үнэт цаас 302.5 сая төгрөгөөр арилжаалагджээ.

9-р сарын 27-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,452.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,976.00 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.06%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,659.9
Зах зээлийн үнэлгээ	2,452,436.5

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,976.00	-0.06% ▼
MSE I индекс	8,869.66	-0.12% ▼
MSE II индекс	7,502.26	0.64% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард санхүүгийн нэгдэл	417,011	557,597,292
Лэндмн ББСБ	7,651,369	546,330,107
Инвескор ББСБ	34,763	65,873,390
Ард Даатгал	42,845	30,275,524
Говь	102,909	29,094,387

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Улсын их дэлгүүр	800.00	14.29% ▲
Ард кредит ббсб	71.49	8.98% ▲
Баянгол зочид буудал	27,900.00	7.31% ▲
Ариг гал	3,200.00	6.67% ▲
Шивээ овоо	2,600.00	4.25% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Авто импекс	1,275.00	-15.00% ▼
Хай би ойл	51.03	-14.99% ▼
Монголын цахилгаан холбоо	403.00	-10.44% ▼
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	108.00	-10.00% ▼
Ремикон	23.02	-7.92% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секюритиз	1,155,833,512
Мирэ Эссет Секьюритис Монгол	1,085,011,099
Гаули	629,127,483
Бумбат-Алтай	91,317,028
Би Ди Сек	86,364,354

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	500.33	532,442
Таван толгой	6,515.00	343,114
МИК Холдинг	13,700.00	283,718
Говь	280.28	218,650
Инвескор ББСБ	1,998.00	143,312

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	210	21,036,750	100,000	100,350	156	15.140%
2	ZGEB-BD-25/04/20-A0236-16.993	2,100	210,735,000	100,000	100,700	156	16.993%
3	ZGEB-BD-27/03/20-A0225-18	706	70,741,200	100,000	100,400	156	18.000%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.12-с
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.09.09-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Зарим үнэт цаасны компаниудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов

Санхүүгийн зохьцуулах хорооноос үнэт цаасны компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргасантай холбоотой Андеррайтерийн тусгай зөвшөөрөл авахад хамгийн багадаа 1 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх, Брокерийн компанийн тусгай зөвшөөрөл 100 сая төгрөг, Дилерийн компанийн тусгай зөвшөөрөл 200 сая төгрөг байхаар тусгасан билээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 250 тоот тогтоолоор хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлээгүй дараах нэр бүхий 10 компанийн дилерийн болон андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

1. "АСЕ энд Т капитал" ҮЦК-ийн дилер, андеррайтерийн
2. "Тэнгэр капитал" ҮЦК-ийн дилер, андеррайтерийн
3. "Блүмсбюри секьюритиес" ҮЦК-ийн андеррайтерийн
4. "Эм ай би жи" ҮЦК-ийн андеррайтерийн
5. "Эф си икс" ҮЦК-ийн андеррайтерийн
6. "Блюскай секьюритиз" ҮЦК-ийн дилерийн
7. "Батс" ҮЦК-ийн дилерийн
8. "Зэт жи би" ҮЦК-ийн дилерийн
9. "Өндөрхаан" ҮЦК-ийн дилерийн
10. "Масдак" ҮЦК-ийн дилерийн эрхүүдийг тус тус хүчингүй болгожээ.

МХБ нь гишүүн 51 компаниа бөгөөд энэхүү шийдвэрийн дагуу андеррайтерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч гишүүн компанийн тоо 19, дилерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч гишүүн компанийн тоо 38 компани болж өөрчлөгджээ.

Эх сурвалж: MarketInfo.mn, Монголын хөрөнгийн бирж

Санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлж байна

Санхүүгийн зохицуулах хороо Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх II үе шатны төсөл"-ийн хүрээнд компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр холбогдох судалгаа хийх, бодлогын зөвлөгөө боловсруулах, зэрэглэл тогтоох байгууллагын тогтолцоог судлах, биржийн бус арилжааны эрх зүйн зохицуулалт, тогтолцооны зарчмыг тодорхойлох зэрэг ажлыг хийхээр тохиролцож, 2019 оны 3-р сараас хэрэгжүүлж эхлээд байна.

Энэхүү төслийн хүрээнд 9-р сарын 17-20-ны өдрүүдэд Япон болон Бангладеш Улсын зэрэглэл тогтоох байгууллагын төлөөллүүд Зэрэглэл тогтоох байгууллагын бодлогын баримт бичиг, ёс зүйн хэм хэмжээ, зэрэглэл тогтоох загвар, салбарын харьцуулалт, зэрэглэл тогтоох онол арга зүйн талаарх сургалтыг хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын мэргэжилтнүүдийн дунд явууллаа.

Мөн ЖАЙКА-аас компанийн бондын зах зээлийн чиглэлээр сонгогдсон зөвлөх баг 2019 оны 9-р сарын 10-20-ны өдрүүдэд ажиллаж компанийн бондын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг судлах, компанийн бондын зах зээлийн талаар санал солилцох зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай уулзалт хийв.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

"Атар өргөө" ХК-ийн хувьцааг худалдан авах санал зарлагдлаа

Монгол улсын хуулийн этгээд "Таван Богд Инвест" ХХК нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтад заасан "Компанийн хувьцаа эзэмшигч дангаараа буюу холбогдох этгээдтэй хамтран, эсхүл хувьцаа эзэмшдэггүй этгээд тухайн компанийн хувьцааг бүхэлд нь, эсхүл хувьцааны хяналтын багцаас дээш хувийг худалдан авахаар сайн дурын үндсэн дээр санал гаргана" гэснийг удирдлага болгон МХБ-ийн үнэт цаасны 2-р ангилалд бүртгэлтэй "Атар Өргөө" ХК-ийн 174,136 ширхэг энгийн хувьцаа буюу нийт энгийн хувьцааг 100 хувь худалдан авах саналыг нийтэд гаргалаа.

Санал гаргаж буй этгээд: "Таван Богд Инвест" ХХК

Санал болгож буй үнэ: 60,200 төгрөг

Худалдан авах тоо ширхэг: 174,136 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2019 оны 9 -р сарын 26

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2019 оны 10-р сарын 31-ний өдрийн 13:00 цаг

Хувьцааны худалдан авах төлбөрийг гүйцэтгэх хугацаа: 2019 оны 11-р сарын 01-ний өдөр

Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 0%

Санал гаргагчийн харилцагч үнэт цаасны компани: "Би Ди Сек ҮЦК" ХК, 75551919-04

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион Оргил 1, Чингисийн өргөн чөлөө 6, Хаан банк цамхаг, 10-р давхар,

Мэйл хаяг: invest@tavanbogd.com

"Атар өргөө" ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид болох "Таван Богд Трейд" ХХК, "Улаанбаатар гурил" ХХК болон "Бэрэн групп" ХХК-ууд тус компанийн нийт хувьцааны 20.13%, 19.93% болон 40%-ийг тус тус эзэмшдэг билээ.

"Таван Богд Трейд" ХХК нь "Улаанбаатар гурил" ХХК-ийг 100% эзэмшдэг байна. "Таван Богд Инвест" ХХК нь энгийн хувьцааны 100%-ийг эзэмшсэнээр "Таван Богд Трейд" ХХК шууд болон шууд бусаар "Атар өргөө" ХК-ийн 60%-ийг эзэмших юм.

Эх сурвалж: "Ти Ди Би Капитал" ҮЦК



Мост финтек: IPO гаргах үйл ажиллагаагаа цуцалжээ

IPO гаргах зөвшөөрөл аваад байсан "Мост финтек" компани олон нийтээс хөрөнгө оруулалт татаж дуусахад 2 сарын хугацаа үлдээд байгаа талаар бид мэдээлж байсан.

Тэгвэл тус компанийн зүгээс өөрийн санаачлагаар IPO гаргах үйл ажиллагаагаа цуцалсан талаар эх сурвалжууд мэдээлэв. Одоогоор ямар шалтгаантай талаар компани болон холбогдох байгууллагуудаас дэлгэрэнгүй мэдээлэл гаргаагүй байгаа юм.

Компанийн хувьд зах зээл дээрээс 4.9 тэрбум төгрөг босгохоор төлөвлөж байсан билээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Сангийн яам: 2019 онд нүүрсний экспортын төлөвлөгөө 2-3 сая тонноор тасалдах эрсдэлтэй

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар ирэх оны төсвийн төслийн талаар танилцууллаа. Тэрбээр Сангийн яам ирэх оны төсвийн төслийг боловсруулахдаа нүүрсний экспортын хэмжээг энэ оныхтой адил хэмжээнд буюу 42 сая тонн, харин зэсийн баяжмалынхыг энэ оныхоос 175 мянган тонн, алтны экспортыг 2 тонноор тус тус бууруулж тооцсоныг онцоллоо. Харин төмрийн хүдрийн экспортын хэмжээг багагүй хэмжээгээр нэмэгдүүлж тооцжээ.

2020 оны эрдсийн ханшийг төсөвт тооцоолохдоо зэсийн үнийг бууруулж, алт, төмрийн хүдрийн ханшийг урьдны тооцооллоос нэмэгдүүлж тогтоосон байна. Харин нүүрсний ханшийг хэвээр хадгалахаар төлөвлөжээ.

Сангийн сайдын тайлбарлаж буйгаар энэ оны эхний хагаст нүүрсний гаргалтад хүндрэл учирсан. Оны төгсгөлд 2019 оны төсвийн зорилтот хэмжээ болох 42 сая тонн биелэхэд хүндрэлтэй бөгөөд 39-40 сая тонн нүүрсний экспортлоо хэмээн харж байгаагаа илэрхийллээ. Зэсийн хувьд “Эрдэнэт үйлдвэр”-ийн уурхай болон Оюутолгойн ил уурхайн хүдрийн агуулга буурч буй нь ирэх онд зэсийн баяжмалын экспорт буурах гол нөхцөл болно гэж тайлбарлалаа.

Ирэх оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг энэ оныхоос 2.1 их наяд төгрөгөөр өсгөж, 11.8 их наяд төгрөгөөр тусгажээ. Харин төсвийн нийт зарлагыг 2019 оноос 2.3 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж 13.9 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцлийг -2.1 их наяд буюу ДНБ-ний -5.1% байхаар тооцсон байна. Төсвийн алдагдлыг цаашид 2022 онд ДНБ-ний 1.4%-д хүргэж бууруулахаар төлөвлөжээ.

2020 оны хэмжээнд Тогтворжуулалтын санд 125 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 977 тэрбум төгрөг хуримтлуулна гэж тооцжээ

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

“Эрдэнэт” үйлдвэр: Хаягдлын аж ахуйн М4, холбох сувгийн ажил дуусав

“Эрдэнэт” үйлдвэрийн Хаягдлын сангийн М4 далан, холбох суваг барьж байгуулах төслийг 5-р сарын 1-нд эхлүүлсэн. Уг ажлыг заасан хугацаанд дуусгаж, бүрэн хүлээлгэн өгсөн байна. Тодруулбал, Хаягдлын аж ахуйн 19 дүгээр даланг эргэлтийн усны 12 дугаар худаг руу холбох сувгийн ажлыг уурхайчид гүйцэтгэжээ.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

БУСАД МЭДЭЭ

Монгол Улсын гадаад өр ДНБ-ий 224%-тай тэнцэж байна

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг Монголбанкны Мөнгөний бодлогын захирал Б.Баярдаваа сэтгүүлчдэд танилцууллаа. Уг төслийг өчигдөр УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьсан юм.

Төрийн мөнгөний бодлогод Монгол Улсын эдийн засагт гарч буй эерэг өөрчлөлтийг бататгах, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, нийт ард иргэд, бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй болгоход чиглэсэн зорилтуудыг тусгажээ. Мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа доор дурдсан хүчин зүйлсийг үндэслэсэн байна.

Монголбанкны Мөнгөний бодлогын захирал Б.Баярдаваа “Нэрлэсэн ДНБ-ийг 2020 онд 41.1 их наяд төгрөг байхаар төсөөлж байна. Эдийн засгийн өсөлт буюу бодит ДНБ-ийг 5.1-6.3 хувьтай байхаар авч үзлээ. Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэж байгаа инфляц 2019 оны эцэст 8 хувь, 2020 оны дөрөвдүгээр улиралд 7.2 хувьтай байх төлөв ажиглагдаж байна. Эдийн засгийн өсөлт энэ жилийн хувьд 7 хувь байх төсөөлөлтэй байна. Төлбөрийн тэнцэл энэ жил ДНБ-ий 2.6 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай байхаар ирэх жил 3.2 хувьтай тэнцэх хэмжээнд алдагдалтай байхаар төсөөлж байна. Төсвийн орлого ба тусламжийн дүн ирэх онд ДНБ-ий 29.6 хувьтай, нийт зардал ба цэвэр зээлийн дүн 32.1 хувьтай тэнцэх тооцоо гарсан” гэв. Эдгээр тооцоо судалгаанд Засгийн газраас өргөн барьсан төсөвтэй холбоотой өөрчлөлт орж болзошгүйг тэрбээр онцоллоо.

Нүүрсний хилийн үнэ энэ онд 74 орчим ам.доллар, ирэх жил 67 ам.доллар, зэсийн үнэ 6,000 ам.доллар, алтны энэ жилийн дундаж үнэ энэ онд 1,350 ам.доллар, ирэх онд 1,410 ам.доллар, нефтийн үнэ 64 орчим ам.доллар байх төсөөлөл гарчээ. Төмрийн хүдрийн үнэ 82 орчим ам.доллар байсан нь ирэх жил 73 ам.доллар болж буурна. Монгол Улсын гадаад өрийн хэмжээ нэрлэсэн дүнгээр 29.5 тэрбум ам.доллар байгаа нь ДНБ-ий 224 орчим хувьтай, экспортын орлогын 430 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн байна. Үүнээс Засгийн газрын өр хоёр орчим тэрбум ам.доллар байна. Нийт өрийн тал хувийг буюу 14 тэрбум ам.долларыг 2020-2024 онд эргүүлж төлнө. 14 тэрбум ам.доллар нь өнөөгийн манай гадаад валютын нөөцийг гурав нэмэгдүүлсэнтэй тэнцэнэ. Засгийн газар эдгээр өр төлбөрийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг багасгах үүднээс дахин санхүүжилттэй хослуулан төлөх стратегийг баримталж байна.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.